



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР ЭМЧ,
ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУДЫН ҮНДСЭН ЦАЛИН 1.4-2.0 ДАХИН ӨСӨЖ, ИРГЭД ЭРҮҮЛ
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАА СОНГОН ҮЙЛЧЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ БҮРДСЭН БАЙНА

**АУДИТЫН СЭДЭВ: “ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ”**

АУДИТЫН КОД: ДАА-2023/19-7-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дархан-Уул аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Санжаажав

Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70378845 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

Аудитор Ч.Гантулга

Утас: 70378845 Цахим хаяг: gantulgachu@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар

Утас: 70378845 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Аудитор Н.Отгонцэцэг

Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

Аудитор З.Мөнгөнцэцэг

Утас: 70378845 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

Аудитор О.Мягмарсүрэн

Утас: 70378845 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn

Аудитор Э.Одгэрэл

Утас: 70378845 Цахим хаяг: odgerele@audit.gov.mn

АГУУЛГА

А. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДСАН БАЙНА	5
А.1 Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна.	5
А.1.1. МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ЭМД-ын талаар тусгасан зорилт, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлж ажилласан байна.....	5
А.1.2. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл хуульд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна	6
А.1.3. Эмнэл зүйн олон улсын удирдамжийг эмнэлгийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглаж байна	6
Б. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг үзүүлж байна	6
Б.1. Аудитаар ЭМДС-аас 114 тохиолдолд 57.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ.....	6
Б.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна	6
Б.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтэд хяналт тавих чиг үүргээ аймгийн ЭМДХ хэрэгжүүлж ажилласан байна	7
Б.1.3. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн орон тоог нэмж, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан байна.....	8
Б.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг ЭМДЕГ-аас сонгон шалгаруулсан байна.	9
Б.1.5. Эмийн сангуудын даатгалын гэрээний гүйцэтгэлийн үнэлгээ хийгджээ	9
Б.1.6. Санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөлт орсон нь иргэд эрүүл мэндийн байгууллагаа сонгон үйлчлүүлэх нөхцөл бүрдсэн байна	9
Б.2. ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ НЬ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛСЭН Ч НЭГ ЭМЧ, СУВИЛАГЧИД НОГДОХ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО СТАНДАРТТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА	11
Б.2.1. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амын тоог тодорхойлох судалгаа хийгээгүй байна.	11
Б.2.2. Иргэдийг мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудын цахим системд сайжруулалт хийх шаардлагатай байна.	13
Б.2.3. Даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж, өргөдөл гомдлыг хууль, журмын дагуу шийдвэрлэсэн байна.....	16
Б.3. Аймгийн ЭМДЕГ болон ЭМДХ хуульд заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлсэн байна..	16
Б.3.1. Эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг бодитой үнэлсэн байна	16
Б.3.2. Аймгийн ЭМДХ-ийн хянасан төлбөрийн нэхэмжлэлд аудитаар 5.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ	16
Б.3.3. ЭМДЕГ-ын ДАХШҮГ-аас аймгийн ЭМДХ-ийн нэхэмжлэлийн хяналт болон сангийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажилласан байна.	17
Б.3.4. Эрүүл мэндийн даатгалын хэлтэст нь төсөв, хөрөнгө захиран зарцуулдаггүй байна ...	18
ДҮГНЭЛТ:	30
ЗӨВЛӨМЖ:	30

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМДШ	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бодлогын баримт бичигтэй уялдсан байдал	6
Хүснэгт 2	ЭМД-д хамралтын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 3	Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт /төрлөөр/	11
Хүснэгт 4	Дархан-Уул аймгийн ӨЭМТ-ийн 1 эмчид ногдох иргэдийн тоо	13
Хүснэгт 5	ЭМДС-аас нэхэмжилсэн дүн, олгосон санхүүжилт	18

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	ЭМДШ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	7
График 2	ЭМД-ын сангаас олгосон санхүүжилт	9
График 3	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан иргэдийн мэдээлэл	10
График 4	Эрүүл мэндийн салбарын ажилчдын дундаж цалин	12
График 5	Иргэдээс авсан санал асуулгын үр дүн	14
График 6	Цахим программын эрхтэй албан хаагчийн тоо	14
График 7	Иргэдээс авсан санал асуулгын үр дүн	16
График 8	ЭМД, ЭМ-ийн тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авдаг эх сурвалж	16

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Эрүүл мэндийн цахим системийн судалгаа	15

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Түүвэрт хамрагдсан эмийн сангийн тулгалт	24

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг ЯАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх • Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, өрхийн болон сумын эрүүл мэндийн төвүүд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, аудитын менежер У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Санжаажав, аудитор Ч.Гантулга, Б.Алтанзул, Г.Батмягмар, Н.Отгонцэцэг, З.Мөнгөнцэцэг, О.Мягмарсүрэн, Э.Одгэрэл нар гүйцэтгэсэн.
Хүндрэл бэрхшээл	Аудитын явцад хүндрэл бэрхшээл гараагүй болно.

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 7/16.

Дархан сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон 63/01-A0960289-ДАА-2023/19-7-ШТА-ГА тоот төлбөрийн актыг баталсугай.

3. Аудитын тайланг Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал, Эрүүл мэндийн газрын дарга Б.Батцэнгэл, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга А.Энхчимэг, Нэгдсэн эмнэлгийн дарга Б.Мөнхбат нарт хүргүүлсүгэй.

4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга Б.Батцэнгэл, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга А.Энхчимэг, Нэгдсэн эмнэлгийн дарга Б.Мөнхбат нарт зөвлөсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгч, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын баг (ахлах аудитор С.Санжаажав)-т үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Батсүрэн)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

009010035

D:\Bichig hereg\Tushaai.docx

А. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДСАН БАЙНА

А.1 Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна

А.1.1. МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ЭМД-ын талаар тусгасан зорилт, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлж ажилласан байна

1.1.1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой тогтолцоог нэвтрүүлэх, эрүүл мэндийн даатгалын чанар, тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого, зорилтыг тодорхойлжээ.

Хүснэгт 1. Бодлогын баримт бичигтэй уялдсан байдал

Хөгжлийн бодлогын баримт бичиг						
№	Байгууллагын нэр	Арга хэмжээний тоо	Алсын хараа-2050 I үе шат (2021-2030)	МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө
1	Эрүүл мэндийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ	5	2.2.2, 2.2.6,	2.2.2, 2.2.5, 2.2.7	2.1.7.2, 2.1.7.4, 2.1.7.5, 2.1.7.10, 2.1.7.12	2.1.12, 2.1.13, 2.1.24
2	Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө	5	2.2.2, 2.2.6,	2.2.2, 2.2.5, 2.2.7	2.1.7.2, 2.1.7.4, 2.1.7.5, 2.1.7.10, 2.1.7.12	2.1.12, 2.1.13, 2.1.24
3	Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн төлөвлөгөө	5	2.2.2, 2.2.6,	2.2.2, 2.2.5, 2.2.7	2.1.7.2, 2.1.7.5, 2.1.7.8, 2.1.7.10, 2.1.7.12	2.1.12, 2.1.13, 2.1.24

1.1.2. Дээрх зураглалаас харахад Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээ харилцан уялдаатай байна.

1.1.3. Хөгжлийн бодлого, зорилт, арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт оруулж, ЭМДҮЗ-ийн тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ батлах тухай журмыг шинэчлэн боловсруулах ажлууд хийгджээ.

1.1.4. Мөн 2021 оноос гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эмнэл зүйн олон улсын сайн туршлага, “Up to date” платформыг оношилгоо, эмчилгээндээ нэвтрүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахаар нэвтрүүлсэн байна.

А.1.2. ЭМДҮЗ нь эрүүл мэндийн байгууллагаас хүргүүлсэн гомдлыг шийдвэрлэсэн талаар хариуг ирүүлээгүй байна

1.2.1 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д Үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоонд байна гэж тусгаж, 14.8, 14.9-д Үндэсний зөвлөлийн эрх, үүргийг тодорхой зааж өгчээ.

1.2.2. Үндэсний зөвлөл нь хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.7-д “эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” гэж заасны дагуу асуудлыг шийдвэрлэсэн тухай албан бичгээр хариу хүргүүлж ажиллаагүй байна. Тодруулбал ЭМДЕГ-т аймгийн Нэгдсэн эмнэлгээс 2021 оны 1/200, 2022 оны 1/417, 1/540, 1/753 тоот албан бичгүүдийн талаар арга хэмжээ авч шийдвэрлэсэн хариуг ирүүлээгүй байна.

А.1.3. Эмнэл зүйн олон улсын удирдамжийг эмнэлгийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглаж байна

1.3.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д заасныг үндэслэн Монгол Улсын ЭМД-ийн системд 2021 оны 1 дүгээр сараас эхлэн тусламж үйлчилгээний эмнэл зүйн олон улсын удирдамж "Up to date" платформыг нэвтрүүлэн ашиглаж байна.

1.3.2. Ингэснээр үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог олон улсын жишгийн дагуу зохион байгуулах нөхцөл, суурийг бий болгожээ.

Б. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг үзүүлж байна

Б.1. Аудитаар ЭМДС-аас 114 тохиолдолд 57.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ

Б.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна

1.1.1. ЭМДҮЗ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.1¹-д заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулж, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталжээ.


1.1.2. Аймгийн ЭМД-ын хэлтэс эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагыг төлөвлөж, батлуулах чиг үүрэг хуулиар хүлээгээгүй тул төсвийн төлөвлөлтөд ямар нэгэн санал хүргүүлдэггүй байна.

1.1.3. ЭМДҮЗ-ийн 2021 оны 01, 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/11, 2022 оны А/14 дүгээр тушаалаар 2021, 2022 оны аймаг, нийслэлийн эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг төлөвлөгөөг тус тус баталсан байна.

¹ Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

График 1. ЭМДШ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөгөөр)



1.1.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сүүлийн 3 жилээр харьцуулахад 2022 оны орлогыг өмнөх оноос 8,509.5 сая төгрөг буюу 90.6 хувиар нэмж баталжээ.

1.1.5. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон ЭМД-ын шимтгэлийн хувь өөрчлөгдөөгүй байхад орлогыг нэмж баталснаас гүйцэтгэл 64.5 хувьтай гарч, орлогын төлөвлөгөө тасарсан байна.

1.1.6. Гүйцэтгэл өмнөх оноос 2,023.8 сая төгрөгөөр өссөн нь хамралтын төлөвлөгөөг 17.4 хувиар давуулж, 1,473 иргэн хамруулсантай холбоотой.

Хүснэгт 2. ЭМД-д хамралтын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хамруулах зохих иргэд	2021 он		2022 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Малчид	1,100	576	1,000	771
2	Оюутан, сурагчид	4,000	661	2,200	804
3	Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд	10,500	7,210	9,450	8,345
Нийт		15,600	8,447	12,650	9,920

1.1.7. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-д “Энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.8-д заасан шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.” гэж заасны дагуу ЭМДЕГ НДЕГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Гэрээний дагуу Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын хэлтсүүд 2022 оноос эхлэн нээлттэй хаалганы өдөрлөг, хамралтын аяныг 2 удаа зохион байгуулан ажиллажээ.

Б.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтэд хяналт тавих чиг үүргээ аймгийн ЭМДХ хэрэгжүүлж ажилласан байна

1.2.1. ЭМДҮЗ 2021 оны 03 дугаар тогтоолоор ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн

жагсаалт, төлбөрийн хэмжээ, өртгийн жинг, 04 дүгээр тогтоолоор баталсан ЭМД-ын сангаас санхүүжүүлэх журмаа 2022 онд шинэчилсэн байна.

1.2.2. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс ЭМДҮЗ-өөс баталсан уг журам, аргачлалыг баримтлан ЭМД-ын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээнд нэхэмжлэхийн хяналтыг хэрэгжүүлж, санхүүжилтийг олгох саналыг ЭМДЕГ-т хүргүүлдэг байна.

График 2. ЭМД-ын сангаас олгосон санхүүжилт



1.2.3. ЭМД-ын сангаас санхүүжилт авахаар гэрээ байгуулсан төрийн болон хувийн хэвшлийн 69 байгууллага 2021-2022 онд нийт 75,901.4 сая төгрөг нэхэмжилснээс хяналтаар 5,172.0 сая төгрөгийг хасаж, 70,729.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

1.2.4. Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс санхүүжилтийн нэхэмжлэхэд цахимаар болон нарийвчилсан хяналтыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудтай хагас, бүтэн жилийн эцэст олгохоор тооцсон санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ЭМДЕГ-т тайлагнаж байна.

Б.1.3. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн орон тоог нэмж, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан байна

1.3.1. ЭМДЕГ-ын даргын 2020 оны А/136 дугаар тушаалаар аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийг чанар, төлбөрийн мэргэжилтэн гэсэн 2 орон тоотой байхаар баталсныг 2022 оны А/10 дугаар тушаалаар бүтцийн нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн орон тоог 5 болгон нэмжээ.

1.3.2 ЭМДЕГ-ын даргын 2020 оны А/136 дугаар тушаалаар бүтэц, орон тоог шинэчилсний дагуу чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан 2021 оны А/45 дугаар тушаалаар баталгаажуулсан байна.

1.3.3 Дээрх албан тушаалд ажиллах эмч мэргэжилтэй иргэн төрийн албаны нөөцөд цөөн байдагтай холбоотойгоор чанар төлбөрийн хяналтын мэргэжилтний албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг “анагаах ухаан” гэснийг “эрүүл мэнд” болгон өөрчилж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 70 тоот тогтоолоор баталжээ.

1.3.4. Аудитаар аймгийн ЭМДХ-ийн албан тушаалтнууд дээрх тогтоолоор баталсан мэргэжлийн болон тусгай шалгуурыг хангасан эсэхийг тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

1.3.5. Аймгийн ЭМДХ-ийн үйл ажиллагааны урсгал зардлыг ЭМДЕГ-аас бүрэн санхүүжүүлдэг байна.

Б.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг ЭМДЕГ-аас сонгон шалгаруулсан байна

1.4.1 ЭМДҮЗ-ийн 2018 оны 09, 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын 3.1-д заасны дагуу орон нутагт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг, эмийн сангуудын сонгон шалгаруулалтыг 2021 онд ЭМДЕГазарт, 2023 онд ЭМДЕГ-ын selection.1818.mn, gereeelt@emd.gov.mn зэрэг цахим хуудсаар явуулсан тул аймгийн ЭМДХ сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцоогүй байна.

Б.1.5. Эмийн сангуудын даатгалын гэрээний гүйцэтгэлийн үнэлгээ хийгджээ

1.5.1 Дархан-Уул аймагт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг төр хувийн хэвшлийн 12 эмнэлэг, 1 сувилал, сумын болон өрхийн ЭМТ 8, эмийн хөнгөлөлт үзүүлдэг 48 эмийн сан, нийт 69 эрүүл мэндийн байгууллага ЭМДЕГ-тай гэрээ байгуулжээ.

1.5.2 Аймгийн ЭМД-ын хэлтэс дээрх эрүүл мэндийн төв, эмийн сангийн гэрээний гүйцэтгэлийг ЭМДҮЗ-ийн тогтоолоор баталсан “Даатгалын гэрээ дүгнэх, үнэлэх журам”, ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/175, 2022 оны А/03, 2023 оны А/01 тушаалыг үндэслэн дүгнэсэн байна. Гэрээ дүгнэсэн байгууллагуудын гэрээний гүйцэтгэл 84-88 хувь буюу хангалттай гэж үнэлэгджээ. Харин хувийн эмнэлгүүдийн гэрээг орон нутагт дүгнэдэггүй байна.

1.5.3 Аудитаар гэрээний гүйцэтгэлийг бодитой дүгнэсэн эсэхийг шалгахад “Хангай”, “Анагаах тун”, “Од”, “Мишээл”, “Тэс”, “Фламинго”, “Хос мишээл”, “Армон-Ундраа”, “Шижир”, “Сод фарм” эмийн сангууд MNS5260:2015 стандартын А хавсралтад заасан хүн хүчний хангамжийн шаардлагыг хангаагүй, НДШ-ийг бодит цалин хөлснөөс тооцдоггүй, “Очиртуяа” эмийн сан хөнгөлөлттэй эмийн жагсаалт бүхий самбар байршуулаагүй зэрэгт зөрчилтэй байхад маш сайн буюу 90 хувиас дээш үнэлсэн байна. (дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)

Б.1.6. Санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөлт орсон нь иргэд эрүүл мэндийн байгууллагаа сонгон үйлчлүүлэх нөхцөл бүрдсэн байна

1.6.1 Дархан-Уул аймагт 2022 оны жилийн эцсийн байдлаар ЭМДЕГ-тай гэрээ байгуулсан нийт 69 байгууллага эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

1.6.2 Дээрх байгууллагад олгосон санхүүжилт 2022 онд 26,217.4 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 56.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Олгосон санхүүжилтийн мэдээлэл

(сая төгрөгөөр)


№	Байгууллага	2021 он	2022 он
1	Нэгдсэн эмнэлэг	9,938.0	16,822.9
2	Сумдын эрүүл мэндийн төв	141.9	127.2
3	Өрхийн эрүүл мэндийн төв	192.3	378.5
4	Да-Оюут сувилал	1.0	127.0
5	Хувийн хэвшлийн эмнэлэг	4,585.3	6,658.4
6	Эмийн сан	1,870.6	2,103.4
	Нийт	16,729.1	26,217.4

Эх сурвалж: Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс ирүүлсэн судалгаа

1.6.3. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэд төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас сонгон үйлчлүүлэх нөхцөл бүрджээ.

1.6.4. Тухайлбал аймгийн эрүүл мэндийн газраас гаргадаг статистик мэдээнд дүн шинжилгээ хийхэд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн тоо жил бүр тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

График 3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан иргэдийн мэдээлэл




Эх сурвалж: Аймгийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн судалгаа

1.6.5. Мөн аймгийн нэгдсэн эмнэлэг болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ажилтнуудын цалин хөлсний өөрчлөлтийг харьцуулахад үндсэн цалин 1.4-2.0 дахин өссөнөөс гадна давсан орлогоос эмч, эмнэлгийн ажилтнуудад гүйцэтгэлийн урамшуулал олгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж бүрджээ.

График 4. Эрүүл мэндийн салбарын ажилчдын дундаж цалин, хөлс

(төгрөгөөр)



1.6.6. Бодит гүйцэтгэлээр санхүүжилт олгож эхэлснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн, эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын цалин нэмэгдсэн зэрэг үр нөлөө бий болжээ.

1.6.7. Аудитаар даатгалын гэрээтэй 32 эрүүл мэндийн байгууллагын 4,903 өвчний түүх, 541 өдрийн эмчилгээ, 974 сэргээн засах эмчилгээ зэрэг нийт 6,418 үйлчлүүлэгчийн тохиолдлыг түүвэрт хамруулан шалгахад ЭМДС-аас 8 эмнэлгийн 114 зөрчилтэй тохиолдолд 57.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ.

1.6.8. Энэ нь үндсэн онош зөрүүтэй, оношийг батлах шинжилгээ оношилгоо хийгдээгүй, үндсэн болон ялгах онош бичээгүй, эмчийн үзлэгийн тэмдэглэл хөтлөөгүй, хяналтаар хасалт хийгээгүй, дагалдах эмчилгээ хийгээгүй, анхан шатны баримтын хөтлөлт дутуу, код ахиулсан, шалгуур хангаагүй зэрэг зөрчлүүд болно.

1.6.9. Мөн ЭМДЕГ-тай гэрээтэй эмийн сангуудыг MNS 5260:2015 стандартын шаардлага хангасан эсэхийг шалгахад эмийн сангийн ангилал, удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, хангамжийн шаардлага хангаагүй 11 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь гүйцэтгэлийн гэрээг бодитой дүгнэдэггүй, эмийн сангийн үйл ажиллагаанд явцын хяналт шалгалт хийгээгүйтэй холбоотой байна.

Б.2. ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ НЬ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛСЭН Ч НЭГ ЭМЧ, СУВИЛАГЧИД НОГДОХ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО СТАНДАРТТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА

Б.2.1. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амын тоог тодорхойлох судалгаа хийгээгүй байна

2.1.1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, өвчнийг эрт илрүүлэх, эмчилгээ

үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, дундаж наслалтыг уртасгах зорилт дэвшүүлжээ.

2.1.2. Аймгийн Эрүүл мэндийн газар байгууллагын 2021-2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг эрүүл мэндийн тухай хууль, МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого зэрэгтэй уялдуулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүх нийтийг хамруулах, хэнийг ч орхигдуулахгүй байх гэсэн зарчмыг баримтлан боловсруулжээ.

2.1.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Эрүүл оюутан-Эерэг хандлага”, “Эрүүл хүүхэд-Эрүүл шүд”, хөдөөгийн болон алслагдсан хүн амд “Явуулын амбулатори”, “Малчдын эрүүл мэндийн сар”, хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран зорилтод бүлгийн эмэгтэйчүүдэд “Гарц” гэх мэт хөтөлбөр, аяныг зохион байгуулсан байна.

2.1.4. Гэвч аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлох судалгаа хийгээгүй, мэдээлэлгүй байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.2², 13 дугаар зүйлийн 13.3³-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2.1.5. Монгол Улсад мөрдөгдөж буй MNS 5292:2017 стандартаар 1 эмчид 1800-2000 үйлчлүүлэгч ногдохоор байгаа боловч Дархан суманд үйл ажиллагаа явуулдаг өрхийн эрүүл мэндийн төвийн 1 эмчид стандартад зааснаас 136-932 үйлчлүүлэгч илүү ногдож байна.

Хүснэгт 4. Дархан-Уул аймгийн ӨЭМТ-ийн 1 эмчид ногдох иргэдийн тоо


№	ӨЭМТ-ийн нэр	Харьяалагдах багийн иргэдийн тоо	Эмчийн тоо		1 эмчид ногдох хүний тоо	Ажлын байрны мкв	
			Стандарт-аар	Одоо ажиллаж байгаа		Стандарт-аар	Одоо ажиллаж байгаа
1	Амин-холбоо	13,696	8	7	1,957	556	278
2	Гэрэлтэй	11,575	6	5	2,315	504	254
3	Гос-хот	32,531	18	17	1,914	1,336	668
4	Түвшин-Холбоо	11,729	6	4	2,932	685	685
5	Мэдс-тоб	18,064	10	8	2,258	1,200	600
Дүн		87,595	48	41	2,275	4,281	2,485

2.1.6. Мөн ажлын байрны талбайн хэмжээ 2 дахин бага байгаа нь үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Аудитаар иргэдээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ихэвчлэн ямар байгууллагаас авдаг талаар судлахад оролцогчдын 41 хувь нь сум, өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлдэг гэж хариулжээ.

² харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах;

³ Эрүүл мэндийн байгууллага нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дангаараа болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран явуулна.

График 5. Иргэдээс авсан санал асуулгын үр дүн



2.1.7. Харин аймгийн эрүүл мэндийн газраас сүүлийн таван жилээр буюу 2018-2022 онд амбулаториор үйлчлүүлэгчдийн 50-60 хувь нь сумын болон өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн статистик, тоо мэдээг гаргасан байна.

2.1.8. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хувьд MNS 5095:2017 стандартаар нийт 624 орон тоотой байхаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 509 орон тоотой ажиллаж байгаа бөгөөд стандартаар их эмч 125 байхаас 102, сувилагч 430 байхаас 318 сувилагч байна.


2.1.9. Иймд эмчийн тоог стандартад нийцүүлэх, өрхийн эмнэлгүүдийн үйл ажиллагаа явуулж байгаа байрны асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Б.2.2. Иргэдийг мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудын цахим системд сайжруулалт хийх шаардлагатай байна.

2.2.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8-д “эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх” гэж заасны дагуу эрүүл мэндийн байгууллагууд “Хур” төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг.

2.2.2. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын 648 албан хаагч цахим программыг ашиглаж байна.

График 6. Цахим программын эрхтэй албан хаагчийн тоо



Үүнээс Нэгдсэн эмнэлэг “E-health”, хувийн хэвшлийн эмнэлгүүд “E-clinic”, өрх, сумын эрүүл мэндийн төвүүд “E-health”, “E-hospital”, эмийн сангууд “Orion”, “Maprad” зэрэг цахим программ ашиглаж байгаагаас албан хаагчдын 60 хувь нь “E-health”, 26 хувь нь “E-hospital”, 14 хувь нь “E-clinic” программ дээр ажиллажээ.

Эх сурвалж: Аймгийн ЭМГ-ын статистик мэдээ

2.2.3. Аудитаар эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж буй цахим программын хөгжүүлэлт, давуу болон сул талыг тодорхойлох зорилгоор цахим программын эрхтэй 216 эмч, сувилагчийг санал, асуулгад хамрууллаа. Санал асуулгад

оролцогчдын 36.0 хувь нь цаг хугацаа хэмнэдэг, 35.4 хувь нь даатгуулагчийн мэдээллийг хянах, 13.5 хувь нь өвчний түүхийг харах давуу талтай гэж хариулжээ.

2.2.4. Харин санал асуулгад оролцогчдын 61.8 хувь нь программ гацалт ихтэй, 28.7 хувь нь программын хөгжүүлэлт хангалтгүй, 5.6 хувь нь ашиглахад төвөгтэй гэж хариулсан байна. Цахим программын сул талыг тус бүрээр харуулбал:

Дүрслэл 1. Эрүүл мэндийн цахим системийн судалгаа

"E-HEALTH"	• Программын хөгжүүлэлт хангалтгүй, • Программын гацалт их байдгаас иргэдэд хүлээлт үүсдэг, • Сервер тогтмол унадаг, багтаамж муутай • Нүдний онош 2 нүд тус тусдаа өөр өөр оноштой байхад нэг л үндсэн оношний мэдээлэл ордог,
E-CLINIC	• Программын хөгжүүлэлт хангалтгүй, • Хур системтэй холбогдоогүй учир иргэний регистрийн дугаарыг хийхэд зөв буруу нь харагддаггүй, өөр программд орж хардаг, • Программын гацалт ихтэйгээс үзлэгийн мэдээлэл оруулахад төвөгтэй, олон шат дамждаг
E-HOSPITAL	• Программын хөгжүүлэлт хангалтгүй, • Программын гацалт ихтэй, ажиллагаа их хэрэглэхэд төвөгтэй, олон үйлдэлтэй • ЭМДСангийн нэхэмжлэлийн хяналтын хасагдал харагддаггүй, • Бусад эрүүл мэндийн байгууллагын үзлэгийн талаарх мэдээлэл байхгүй, • Хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн дэлгэрэнгүй мэдээлэл харах боломжгүй

2.2.5. Цахим программын хөгжүүлэлт, гацалтаас болж эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтээ хугацаанд нь бүрэн авч чаддаггүй, тодорхойгүй шалтгаанаар хасуулдаг зэрэг хүндрэлтэй асуудал байгаа талаар санал асуулгын дүнгээр гарсан учраас программд хөгжүүлэлт хийж, сайжруулах шаардлагатай байна.


2.2.6. Эрүүл мэндийн сайдаас ЭМДЕГ-т өгсөн чиглэлийн дагуу сумдын болон өрхийн ЭМТ-д ашиглаж байсан “E-hospital” цахим системийг шаардлага хангахгүй гэдэг шалтгаанаар зогсоож, “health.gov.mn” цахим системийг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс нэвтрүүлж, системийн хөгжүүлэлт, сургалт мэдээллийн ажлыг хийжээ.

2.2.7. Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд хамрагдсан иргэд өөрт үзүүлсэн тусламж үйлчилгээг хянах, сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх, гомдол гаргах, зэрэг иргэний оролцоотой даатгалын хяналтын системийг даатгуулагчдын гар утсаар дамжуулан 2023 оны 1 дүгээр улирлаас мэдээлж эхэлсэн.

2.2.8. Эрүүл мэндийн байгууллагуудаас иргэдийг цахим мэдээллийн системээр дамжуулан шаардлагатай мэдээлэл, үйлчилгээгээр хангаж чадаж байгаа талаар судалгаа авахад оролцогчдын 77.5 хувь нь “Тийм” гэж хариулсан байна.


2.2.9. Харин иргэд эрүүл мэндийн даатгал, тусламж үйлчилгээний талаар хангалттай мэдээлэлгүй болохыг судалгааны дүн харуулж байна.

График 7. Иргэдээс авсан санал асуулгын үр дүн



2.2.10. Аймгийн ЭМД-ийн хэлтэс болон эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээллийг өөрсдийн албан ёсны цахим хуудас болон утсаар дамжуулан мэдээлэл хүргэж байгаа ч судалгаанд оролцогчдын 45.1 хувь нь олон нийтийн сүлжээнээс мэдээлэл авдаг гэж хариулжээ.

График 8. ЭМД, ЭМ-ийн тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг авдаг эх сурвалж



2.2.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс судалгаа авахад оролцогчдын 14.7 хувь нь “Маш сайн болон сайн”, 55.3 хувь нь “Дунд”, 29.9 хувь нь “Муу” гэж хариулжээ.

2.2.12. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг аль нь илүү чанартай, хүртээмжтэй өгч чадаж байна гэсэн асуултад оролцогчдын 54.4 хувь нь “Хувийн эмнэлэг”, 18.8 хувь нь “Нэгдсэн эмнэлэг”, 16.4 хувь нь “Сум, өрхийн ЭМТ”, 10.4 хувь нь бусад гэж хариулсан байна. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагчдын ажлын цаг ашиглалт хангалтгүй, харилцаа, хандлага муу болон дунд гэж судалгаанд оролцогчдын 60-70 хувь нь хариулжээ.

2.2.13. Дээрх судалгааны үр дүнгээс харахад аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчдын ажлын цаг ашиглалт, харилцаа, хандлага зэрэгт байгууллагын удирдлага анхаарч ажиллах шаардлагатай байна.

Б.2.3. Даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж, өргөдөл гомдлыг хууль, журмын дагуу шийдвэрлэсэн байна

2.3.1. Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11¹-т заасны дагуу орон нутгийн телевиз болон өөрийн facebook цахим хуудсаар дамжуулан өдөр тутмын мэдээллийг хүргэдэг байна.

2.3.2. Мөн иргэдийн санал хүсэлтийг хэлтсийн 7037-7505 лавлах утсаар авдаг бөгөөд 2021 онд 211, 2022 онд 371 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн бол ЭМДЕГ-тай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчдад Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомж, дүрэм, журам, хяналтаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар 2021 онд 18 удаа, 2022 онд 14 удаагийн сургалтыг зохион байгуулжээ.

2.3.3. Иргэдээс 2021-2022 онд нийт 7 өргөдөл ирснийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12⁴, 23 дугаар зүйлийн 23.2.2⁵ дахь заалт, холбогдох журмын дагуу шийдвэрлэн, холбогдох хариуг хүргүүлсэн байна.

2.3.4. Дээрх 7-н өргөдлийн 3 нь эмчилгээ, үйлчилгээний төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй, 2 нь эм, эмчилгээний төлбөрийг хувийн зардлаар авсантай холбоотой байв.

Б.3. ЭМДЕГ болон аймгийн ЭМДХ хуульд заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлсэн байна

Б.3.1. Эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг бодитой үнэлсэн байна

3.1.1 Эрүүл мэндийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 2021 онд 98.0, 2022 онд 92.7 хувиар, Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн тайланг 2021 онд 95.0, 2022 онд 97.5 хувиар, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн гүйцэтгэлийн тайланг 2021 онд 98.0, 2022 онд 96.3 хувиар тус тус үнэлжээ.

3.1.2 Аудитаар төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг журмын дагуу үнэлсэн эсэхийг тайлагналд үндэслэн шалгахад харьяалах хяналт-шинжилгээ, дотоод аудитын газар, хэлтсүүд тайлант хугацааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг бодитой үнэлж, баталгаажуулсан байна.

Б.3.2. Аймгийн ЭМДХ-ийн хянасан төлбөрийн нэхэмжлэлд аудитаар 5.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ

3.2.1 Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5¹, ЭМДҮЗ-ийн 2021 оны 05, 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журам”-ын дагуу эрүүл мэндийн байгууллагуудаас даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээнд нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлж 2021 онд 2,114.7 сая, 2022 онд 3,057.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлжээ.

⁴ даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

⁵ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн талаар даатгуулагчийн гаргасан өргөдөл, гомдол, саналыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, даатгуулагчийн эрхийг хамгаалах;

Хүснэгт 5. ЭМДС-аас нэхэмжилсэн дүн, олгосон санхүүжилт

(сая төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Нэхэмжилсэн	Олгосон	Нийт хасагдал	Нэхэмжилсэн	Олгосон	Нийт хасагдал
2021 он					2022 он		
1	Нэгдсэн эмнэлэг	19,312.3	17,870.4	1,441.9	20,822.0	18,375.2	2,446.8
2	Хувийн эмнэлэг	9,308.1	8,929.0	379.1	7,070.9	6,828.7	242.2
3	Сувилал	6.0	1.0	5.0	134.1	127.0	7.1
4	Эмийн сан	2,044.4	2,040.1	4.3	2,266.8	2,244.9	21.9
5	Өрхийн ЭМТ	3,503.0	3,370.5	132.5	5,399.6	5,265.9	133.7
6	Сумдын ЭМТ	2,781.7	2,629.8	151.9	3,252.5	3,046.9	205.6
Нийт дүн		36,955.5	34,840.8	2,114.7	38,945.9	35,888.6	3,057.3

3.2.2 Эрүүл мэндийн байгууллагаас гэрээний дагуу худалдан авах тусламж, үйлчилгээнд чанар болон төлбөрийн хяналтаар гарсан нийт хасагдлын 43.0-45.7 хувийг цахим, 54.3-57.0 хувийг нарийвчилсан хяналтаар илрүүлсэн байна. Хяналтаар дахин давтагдан гарсан зөрчлийг авч үзвэл:

- Тусламж, үйлчилгээг давхардуулан нэхэмжилсэн,
- ЭМД-ын шимтгэл төлөлт байхгүй, регистрийн дугаар алдаатай,
- Гэрээ хийгдээгүй тусламж, үйлчилгээг нэхэмжилсэн
- Онош зөрүүтэй,
- Хэвтүүлэн эмчлэх заалт гаргаагүй,
- Хэвтэх бичиг байхгүй,
- Анхан шатны маягтыг бүрэн хөтлөөгүй,
- Өвчний түүхийн тэмдэглэл байхгүй,
- Үндсэн оношийг батлах оношилгоо, шинжилгээ, эмчийн үзлэг бүрэн хийгдээгүй зэргээс шалтгаалжээ.

3.2.3 Харин эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын чанар болон төлбөрийн нэхэмжлэлд хууль, журмын дагуу хяналт хэрэгжүүлсэн эсэхийг аудитаар давтан шалгахад түүвэрт хамрагдсан 865 төлбөрийн нэхэмжлэлээс 5.6 сая төгрөгийн 11 зөрчилтэй тохиолдлыг илрүүлээгүй байна.

Б.3.3. ЭМДЕГ-ын ДАХШҮГ-аас аймгийн ЭМДХ-ийн нэхэмжлэлийн хяналт болон сангийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

3.3.1. Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд 2021 онд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3.2. Харин 2022 онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16, 17 дугаар зүйл, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дугаар зүйл болон бусад хууль тогтоомж, ЭМДЕГ-ын даргын баталсан 2022/01 дугаар “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийн дагуу ЭМДЕГ-ын ДАХШҮГ-аас ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн төрийн болон

хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад шалгалт хийж 20.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, ЭМД-ийн санд буцаан төвлөрүүлсэн байна.

3.3.3. Мөн 2022 онд аймгийн ЭМД-ийн хэлтсээс эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжлэлийг хянаж 5 эмнэлгээс 34.6 сая төгрөгийн хасалт хийхээр ЭМДЕГ-т хүргүүлснийг ЭМДЕГ-ын ДАХШҮГ дахин хянаж санхүүжилтийг олгосон байна. Энэ нь ЭМДХ-ийн мэргэжилтнүүд түүвэрлэлтийг бүрэн хянаж үзээгүй, зардлын байцаагч зөвхөн бодит цагийн горимыг шалгаж хасалт хийсэнтэй холбоотой байна.

Б.3.4. Эрүүл мэндийн даатгалын хэлтэст нь төсөв, хөрөнгө захиран зарцуулдаггүй байна

3.4.1 Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь төсөв, хөрөнгө захиран зарцуулдаггүй учир Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарахгүй болно.

3.4.2. 2023 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 9 эмнэлгээс 7 эмнэлэг шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж, Орхон сумын эрүүл мэндийн төв 3, Шарын гол сумын өрхийн эрүүл мэндийн төв 1 мэдээлэл тус тус байршуулаагүйд зөвлөмж өгсөн байна. Харин дээрх байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

Холбогдох байгууллагын санал, тайлбар:



МОНГОЛ УЛС
ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГА

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059 Утас: 7037-8023
Факс: 7037-7121, Цахим шуудан: info@darkhan.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gov.mn

2023.05.18 № 1-10/302
танай 2023.05.18 -ны № 204 -т

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус байгууллагаас хүргүүлсэн “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Цаашид хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах болно.

ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

4523100555

D: ZDTG-2023 toot-1



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

45063 Дархан-Уул аймаг, Дархан сум 5 дугаар баг

Утас/Факс: 976-7037-4303

И-мэйл хаяг: darkhan.emg@gmail.com

Вэб сайт: <http://www.darkhan-uul.mohs.mn>

2023.05.17 № 406.
танай 2023.05.16 -ны № 204. -Т

**ДАРХАН -УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, өгөгдсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлж хамтран ажиллах болно.

ДАРГА

Б.БАТЦЭНГЭЛ



ДАРХАН-УУЛ АЙМАГ
НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

45051 Дархан, Дархан-Уул аймаг, 13 дугаар баг

Утас, факс, (976) 7037-7305

E-mail: darkhan.negdsen@gmail.com

Web: www.mohs.da.gov.mn

2023.05.17 № 11487
танай 2023.05.16 -ны № 204 -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд
суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”
сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа. Хариу тайлбаргүй болно.

ЕРӨНХИЙ ЭМЧ
ДАРГА

Б.МӨНХБАТ

С. Санжаахуу-9
Зөвлөхөөсөн хөрөнгийг
хяналт болон
онцлох.
004523040411



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТЭС**

Дархан сум, Дархан-Уул аймаг, 45040

Утас: 7037 7505

Цахим шуудан: darkhanuul@emd.gov.mn,

Цахим хуудас: www.emd.gov.mn

2023.05.18 № 18/159
танай _____-ны № _____-т

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Ш.МӨНХБАЯР ТАНАА**

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан
санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцаж дараахь тайлбарыг хүргүүлэв.

/Хавсралт 116 хуудас



Д/Д	Аудитын тайлангаар	Санал, тайлбар
	1.2.2. Үндэсний зөвлөл нь хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.7-д “эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” гэж заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Тодруулбал ЭМДЕГ-т аймгийн Нэгдсэн эмнэлгээс 2021 оны 1/200, 2022 оны 1/417, 1/540, 1/753 тоот албан бичгүүдээр чанарын хяналтаар санхүүжилт хасагдсан шалтгааныг тодруулах, санхүүжилтийн гүйцэтгэлийг хугацаанд нь хүргүүлсэн байхад санхүүжилтийг олгохгүй байгаа талаар гомдлыг хүргүүлсэн ч хариу ирүүлээгүй байна.	ЭМДЕГ-тай гэрээтэй эрүүл мэндийн байгууллагууд тулгамдаж буй асуудлаа ерөнхий газрын холбогдох газар хэлтэс, мөн тус хэлтэст хандаж албан бичиг илгээдэг. Ерөнхий газарт албан бичигтэй танилцаж зарим тохиолдолд тус хэлтэст эйблээр явуулдаг. Тус хэлтэс нь ЭМБ-уудаас албан тоотой болон цахимаар илгээсэн бичгийн цаг хугацаанд нь шийдвэрлэхэд анхаарч, асуудлыг дээд газраасаа тодруулж, хариуг дээд газраас явуулсан ч бид эрүүл мэндийн байгуулагадаа утсаар мэдээлж чиглэл өгч хамтран ажилладаг. 2021-2022 онд Нэгдсэн эмнэлгээс ЭМДЕГ-т хандаж явуулсан бичиг болон хариу өгсөн талаар дараахь тайлбарыг хийж байна. • 2021.03.26-ны 1/200 тоот албан бичгээр “Улсын төсвийн санхүүжилтийн тухай” бичиг явуулсан байна. ЭМДСан ковидын тусламж үйлчилгээг нэн тэргүүнд санхүүжүүлсэнтэй холбоотой мөн ЭМДСанд улсын төсвийн санхүүжилт хугацаандаа ирээгүйгээс улсын хэмжээнд гүйцэтгэлийг сар дамжуулан олгож, хариуг эйблээр явуулсан байна. • 2022.06.09-ны өдрийн 1/417 тоот бичгээр ЭМДЕГ-т өөрсдийн алдаанаас 146 түүх битүүмжлэгдээгүй тул уг түүхүүдийг нэхэмжилж өгнө үү гэсэн албан бичиг явуулсныг хүсэлтийн дагуу шийдвэрлэж эйблээр албан бичгийг хаасан байна. • 2022.10.25-ны 1/753 тоот бичгээр ЭМДЕГ-үлдэгдэл санхүүжилтийг шийдүүлэх тухай хандсныг СБХ-ээс 10 сарын 25-нд шилжүүлсэн баримтыг хавсаргав. • 2021.08.03-ны 1/540 албан бичгээр тус хэлтэст хандаж 05 дугаар сард яаралтай тусламжийн зардал хасагдсан шалтгааныг тодруулах тухай талаар хандсан байсан. Хэлтсийн зүгээс сар бүрийн хяналтаар хасагдсан тохиолдол бүрийг тасаг нэгж, тусламж авсан хүний нэр регистрээр илэрсэн зөрчлийг ЭМБ-ийн чанарын мэргэжилтэн, даатгалын эмч, эмчилгээ эрхэлсэн орлогч даргад мэдэгдэж тайлангаа хүргүүлж ажилладаг боловч НЭ илэрсэн зөрчлийг цаг хугацаанд нь авч танилцаж хариу баталгаажуулж явуулдаггүй. Мөн нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд ажлын 5 хоногийн дотор бидэнд хариу бичгээр хандаж тайлбар авах талаар гэрээнд тодорхой заасан боловч НЭ-ийн удирдлагын баг хэрэгжилтийг хангаж ажилдаггүй болно. Санхүүжилтийг шилжүүлсэн мөнгөн гүйлгээний баримтыг хавсаргав./Улсын төсвийн санхүүжилт даатгалыг санд цагтаа төвлөрч орж ирдэггүйгээс улсын хэмжээнд ЭМБ-ын санхүүжилт орохгүй тодорхой хугацааны орох нь дан ганц ерөнхий газраас үүсээд байгаа асуудал биш болно. ЗГ-аас хэрэгжүүлж байгаа шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд мэдээлэлийг шуурхай түргэн шийдвэрлэх зорилгоор төрийн байгууллагуудыг мэдээлэлээ цахимаар

		солилцох,цааснаас татгалзах чиглэлийг өгч ,хэрэгжүүлэхийг шаардаж байгаа тул манай ерөнхий газраас гэрээт байгуулагуудын тайлан,анхан шатны маягт,гэрээлэлттэй холбоотой бичиг,албан бичиг тоотыг албан ёсны цахим хаягаар хүлээн авч,цахимаар хариуг хүргүүлж асуудлыг шуурхай шийдвэрлэж байгаа болно. Санал:1.2.2. Үндэсний зөвлөл нь хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.7-д “эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” гэж заасны дагуу асуудлыг шийвэрлэсэн тухайгаа able-р хяналтын картаар бүртгэдэг боловч албан бичгээр хариу хүргүүлж ажиллаагүй байна. Тодруулбал ЭМДЕГ-т аймгийн Нэгдсэн эмнэлгээс явуулсан 2021 оны 1/200, 2022 оны 1/417, 1/540, 1/753 тоот албан бичгүүдийн талаар арга хэмжээ авч шийвэрлэсэн ч хариуг албан бичгээр цаасаар өгч ажиллаагүй байна.
2	Б.1. Аудитаар ЭМДС-аас 114 тохиолдолд 57.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ. Хавсралт-3-ын Б.1.6: Алдааны зөрчлийн товч утгад: 2021-2022 онд үйлчлүүлсэн иргэдийн өвчний түүхээс түүвэр хийж шалгахад оношийн код зөрүү, код ахиулсан, эмчийн үзлэгийн тэмдэглэл дутуу, анхан шатны баримт хөтлөлт дутуу зөрчил илэрлээ.	Тайлбар: ЭМБ-ууд сайн дурын үндсэн дээр төрийн ажлыг хийх хүсэлтээ өгч төрийн ажилыг гүйцэтгэх гэрээ байгуулсан мөртлөө төрөөс хууль дүрмийг хэрэгжүүлэх шаардлага тавихад өөрсдийн эрх ашигт нийцэхгүй л бол төрийг эсэргүүцэж шүүмжилж байдаг. Төрийн хяналт шалгалтаар гэрээт ЭМБ-ууд хийх ёстой зүйлийг хийгээгүй, дүрэм журам хэрэгжүүлээгүй зөрчлийг илрүүлж акт тавьсныг зөв гэж хүлээн авч байна. ЭМСалбарын шинэчлэлийн хүрээнд ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоол 2021.03.01-нээс,ЭМДҮЗ-ийн 05 тогтоол “Нэхэмжлэлийг хянах журам” 2021.08.01-нээс хэрэгжсэн. Өөрөөр хэлбэл ЭМБ-уудаас хэвтэн эмчлүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг хянахдаа онош бүрээр тусгай “шалгуур” хэрэглэж 2021.09 сараас хянадаг болсон. Өмнө нь ЭМДҮЗ-ийн тогтоол, тухайн өвчний эмнэл зүйн удирдамжийн хүрээнд хяналт хийдэг байсан. Иймээс 2021 оны 1-8 сард үзүүлсэн тусламж үйлчилгээг 5 тогтоолын хүрээнд “шалгуур”-аар хянаж шалгаж зөрчил гэж үзэх боломжгүй тул оношийн код ахиулсан гэсэн тайлбартай акт тавих нь үндэслэлгүй гэж үзэж байна.Хэдийгээр эрүүл мэндийн байгууллагууд сонсох ажиллагаагаар актыг хүлээн зөвшөөрсөнч зөрчлийг ирүүлэхэд ашигласан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хугацаа, шалтгааныг эргэж дахин нягтлахгүй бол актыг төлбөрийг барагдуулахад маргаан гарч хүндрэл үүсэх магадлалтай гэж үзэж байна. Санал: Б.1.6. Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас 2021-2022 онд үйлчлүүлсэн иргэдийн өвчний түүхээс түүвэр хийж шалгахад эмчийн үзлэгийн тэмдэглэл дутуу, анхан шатны баримт хөтлөлт дутуу,цахимд илгээсэн онош өвчний түүхэнд бичигдсэн онош зөрүүтэй , 2021 оны 9 сараас хойш түүвэрлэгдсэн тохиолдолд ЭМДҮЗ-ийн 5 тогтоолын хэрэгжилтийг хангаагүйгээс оношийн код зөрүүтэй, код ахиулсан, зөрчил илэрлээ.
3	1.5.3 Аудитаар гэрээний гүйцэтгэлийг бодитой дүгнэсэн эсэхийг шалгахад “Хангай”, “Анагаах тун”, “Од”, “Мишээл”, “Тэс”, “Фламинго”, “Хос мишээл”, “Армон-Ундраа”, “Шижир”, “Сод фарм” эмийн сангууд MNS5260:2015 стандартын А хавсралтад заасан хүн	Тайлбар: УИХ-ын 2020 оны 8 сарын 20 өдрийн хуралдаанаар ЭМС-ийн санхүүжилтийн шинэчлэл хэлэлцэн батлагдаж 2020 оны 11 сарын 01-нээс хөнгөлөлтэй эмээр үйлчлэх хүсэлт гаргасан эмийн сангууд ЭМДЕГ-т холбогдох материалыг илгээж ерөнхий газартай гэрээ байгуулсан. Дарханд 28 эмийн сан даатгалаар үйлчилдэг байсан бол 54 эмийн болж

	хүчний хангамжийн шаардлагыг хангаагүй, НДШ-ийг бодит цалин хөлснөөс тооцдоггүй, “Очиртуяа” эмийн сан хөнгөлөлттэй эмийн жагсаалт бүхий самбар байршуулаагүй зэрэгт зөрчилтэй байхад маш сайн буюу 90 хувиас дээш үнэлсэн байна. /Хавсралт/ 1.6.9. Мөн ЭМДЕГ-тай гэрээтэй эмийн сангуудыг MNS 5260:2015 стандартын шаардлага хангасан эсэхийг шалгахад эмийн сангийн ангилал, удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, хангамжийн шаардлага хангаагүй 11 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь гүйцэтгэлийн гэрээг бодитой дүгнэдэггүй, эмийн сангийн үйл ажиллагаанд явцын хяналт шалгалт хийгээгүйтэй холбоотой байна.	нэмэгдсэн. Шинээр гэрээлсэн 25 эмийн сангийн баримт бичигт 2021оны 3 сард ковидын хатуу хөл хорио, хил гааль хаагдсан, хүн хүчний дутагдалд орсон, эдийн засгийн хямралд орсон зэргээс ковидын хуулийг үндэслэн төрийн байгууллагуудын хяналт шалгалт хийхийг зогсоосон байсанч хэлтсийн зүгээс хяналт шалгалт хийхэд хүний нөөц стандартанд заасан хэмжээнд хүрэхгүй, НД-ын шимтгэлийн өртэй, ХХДХ-ээс доогуур цалингаас шимтгэл төлдөг гэх мэт олон зөрчлийг илрүүлж, зөрчил арилгах хугацаатай улсын байцаагчийн албан шаардлагыг өгч хариуг авч ажилласан. Мөн НД-хэлтэст хандаж эмийн сангуудын цалингийн санг нь шалгуулж 6 сая төгрөгний акт тавиулж барагдуулсан. Мөн 5 эмийн сангийн гэрээг цуцалсан зэрэг арга хэмжээг авч ажилласан.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар НБХ-ийн даргад танилцуулж албан бичиг хүргүүлж байсан./ЭМБ-д тусгай зөвшөөрөл олгох, сунгах ажлыг хугацаанд нь үндэслэлтэй үр дүнтэй хийх, 1,2-р зэрэглэлийн эмийн сангийн стандартаа эргэж харах,өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгааг анхаарах/ Санал:1.5.3 Аудитаар гэрээний гүйцэтгэлийг бодитой дүгнэсэн эсэхийг шалгахад “Хангай”, “Анагаах тун”, “Од”, “Мишээл”, “Тэс”, “Фламинго”, “Хос мишээл”, “Армон-Ундраа”, “Шижир”, “Сод фарм” эмийн сангууд MNS5260:2015 стандартын А хавсралтад заасан хүн хүчний хангамжийн шаардлагыг хангаагүй байхад хангалтай гэж үнэлсэн байна.
4	1.6.7. Аудитаар даатгалын гэрээтэй 32 эрүүл мэндийн байгууллагын 4,903 өвчний түүх, 541 өдрийн эмчилгээ, 974 сэргээн засах эмчилгээ зэрэг нийт 6,418 үйлчлүүлэгчийн тохиолдлыг түүвэрт хамруулан шалгахад ЭМДС-аас 8 эмнэлгийн 114 зөрчилтэй тохиолдолд 57.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ. 1.6.8. Энэ нь үндсэн онош зөрүүтэй, оношийг батлах шинжилгээ оношилгоо хийгдээгүй, үндсэн болон ялгах онош бичээгүй, эмчийн үзлэгийн тэмдэглэл хөтлөөгүй, хяналтаар хасалт хийгээгүй, дагалдах эмчилгээ хийгээгүй, анхан шатны баримтын хөтлөлт дутуу, код ахиулсан, шалгуур хангаагүй зэрэг зөрчлүүд болно. Дүгнэлт: ЭМДХ-ээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа гэрээтэй байгууллагуудад сургалт, зөвлөгөөг тухай бүр хийж байгаач нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн зөрчлийн тоо өссөн байна. ✓	Тайлбар: Тус хэлтэс цахимын болон нарийвчилсан хяналтаар илрүүлсэн зөрчил, хасагдлын шалтгааны талаар ЭМБ-ын чанарын мэргэжилтэн, тасгийн эрхлэгч, эмчилгээ эрхэлсэн орлогч, эмчлэгч эмч, даатгалын их бага эмч нарт байнга мэдээлэл өгч, тайланг хэвлэж өгч ажилладаг. ХХЭМБ зөрчлөө хурдан арилгах арга хэмжээ авдаг бол улсын эмнэлгийн удирдлага, ЭМГ зөрчил арилгах тал дээр огт ажиллаггүйгээс зөрчлийн тоо буурахгүй байна. Мөн лавлагаа шатлалын эмч нар олон улсын эмнэлзүйн удирдамжийг ашигладаггүйгээс тусламж үйлчилгээний чанар хангалтгүй үнэлэгдэж зөрчлийн тоо нэмэгдсээр байна. Лавлагаа болон анхан шатлалын ЭМБ-аас тогтоол шийдвэр, хяналтын шалгуурын талаар хэргэжүүлэхэд хүндрэлтэй асуудал, өөрчлөх саналыг ерөнхий газраас байнга авдаг боловч эрүүл мэндийн газар, НЭ-ийн эмч нар санал хүргүүлэх ажлыг огт зохион байгуулдаггүй. Нэгэнт батлагдаад гарсны дараа шүүмж дэвшүүлж асуудал тавьдаг. Зөрчлийн шалтгааныг бууруулахад талаар ЭМГ, НЭ-ийн удирдлагууд, тасаг нэгжүүд санаачлагатай, хариуцлагатай ажиллах хэрэгтэй. Санал:1.6.7. Аудитаар даатгалын гэрээтэй 32 эрүүл мэндийн байгууллагын 4,903 өвчний түүх, 541 өдрийн эмчилгээ, 974 сэргээн засах эмчилгээ зэрэг нийт 6,418 үйлчлүүлэгчийн тохиолдлыг түүвэрт хамруулан шалгахад эмнэлэгүүд цахимын болон нарийвчилсан хяналтаар ирүүлсэн зөрчлийг арилгах чанарыг сайжруулах арга хэмжээ авдаггүй, эмч нартай хариуцлага тооцохгүй байдал давтагдаж байгаагаас, ЭМДС-аас 8 эмнэлгийн

		114 зөрчилтэй тохиолдолд 57.1 сая төгрөгийн санхүүжүүлсэн олгосон зөрчил илэрлээ. Санал: 1.6.8. Мөн үндсэн онош зөрүүтэй, оношийг батлах шинжилгээ оношилгоо хийгдээгүй, үндсэн болон ялгах онош бичээгүй, эмчийн үзлэгийн тэмдэглэл хөтлөөгүй, дагалдах эмчилгээ хийгээгүй, анхан шатны баримтын хөтлөлт дутуу, код ахиулсан, шалгуур хангаагүй зэрэг зөрчлүүдэд хяналтаар хасалт хийгээгүй байна. –! Санал /Дүгнэлт:/ ЭМДХ-ээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа гэрээтэй байгууллагуудад сургалт, зөвлөгөө, хяналт шалгалтаар ирүүлсэн зөрчлийн талаар эрүүл мэндийн байгууллагад мэдээлэлийг хүргүүлж байгаа боловч нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн зөрчлийн ариллахгүй байгаа нь эрүүл мэндийн байгууллагууд шинэчлэлийг хангалтгүй хэрэгжүүлж байна.
5	3.3.3. Мөн 2022 онд аймгийн ЭМД-ийн хэлтсээс эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжлэлийг хянаж 5 эмнэлгээс 34.6 сая төгрөгийн хасалт хийхээр ЭМДЕГ-т хүргүүлснийг ЭМДЕГ-ын ДАХШҮГ дахин хянаж санхүүжилтийг олгосон байна. Энэ нь ЭМДХ-ийн мэргэжилтнүүд түүвэрлэлтийг бүрэн хянаж үзээгүй, зардлын байцаагч зөвхөн бодит цагийн горимыг шалгаж хасалт хийсэнтэй холбоотой байна. Дүгнэлт: Нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ түүвэрлэлтийг бүрэн хянаж үзээгүй, зөвхөн бодит цагийн горимоор хянасан зэргээс эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтээ хасуулах, зөрчилтэй тохиолдлыг илрүүлэхгүй байх зэрэг эрсдэлийг бий болгосон байна. Дүгнэлт: Түүвэрт хамрагдсан нэхэмжлэлийг чанартай гүйцэтгэж байх.	ЭМСалбарын шинэчлэлтийг даатгалын байгууллага ЭМБ-тай хамт нэг цэгээс суралцаж, хэрэгжүүлж эхэлсэн. Бидэнд цахим өгөгдөлтэй танилцах, шинэ тогтоол шийдвэрийг уншиж судлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах, хяналтын шалгалтын шинэ аргад суралцах, ЭМБ-уудыг мэдээллээр хангах, чиглэл өгөх гэх мэт олон мэдэхгүй зүйлүүдтэй тулгарч байлаа. Энэ үед ковидын тархалт өвчлөл эрс ихэссэнтэй холбоотой НЭ халварт бус өвчлөлөө авч эмчлэх боломжгүйд хүрч, АОК-ын шийдвэрээр хувийн эмнэлгүүд хүний нөөц боломж дээр тулгуурлаж /Саран элит эмнэлэг мэдрэл, мэс заслын өвчин, Буянтай Цээнэ эмнэлэг дотор зүрх судасны өвчин, Цанид мэдрэл уламжлалт/ НЭ-ийн ачаалалыг хуваалцаж, цаашид ковидын халдвар улам нэмэгдснээр ЭМГ-т НЭ байрлаж, ХХЭМБ-ууд ковидын тусламж үйлчилгээг үзүүлж, тусгаарлан эмчлэх байр нэмэгдэж ковидын тусламжийн зардал маш ихээр нэхэмжлэгдэж орж ирж байсан. Энэ хүнд үед хэлтэс 2 мэргэжилтэнтэй /2021.07 сараас 1 эмч нэмэгдсэн/ хэдий ч ачаалал маш их байсан учир ердийн зарим тусламж үйлчилгээг гүйцэт хянах хугацаа байхгүй байсан. Ковидын тусламж үйлчилгээний хяналтанд түлхүү анхаарч ажиллаж байсантай холбоотой түүвэрлэлтэнд унасан тохиолдлыг дутуу хянах, ханахгүй илгээх тохиолдолд ДАХШҮГ-аас зөрчлийг илрүүлж анхааруулж, зөвлөмж чиглэлийг өгч байсан. Санал: 3.3.3. ЭМДЕГ-ын ДАХШҮГ-аас ковидын үеийн тусламж үйлчилгээ болон шинээр хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд дотоод хяналтыг хийж түүвэрлэгдсэн тохиолдолд хяналт хийгээгүй зөрчлийн талаар тайлбар авч сонсох ажиллагааг явуулж ажилласан байна. Санал /дүгнэлт:/ Түүвэрт хамрагдсан бүх тохиолдлуудад хяналт хийсэн талаар давхар хяналт хийж хэвших

Жич: 2021-2022 онуудад эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн эхлэл, дэлхийн нийтийг хамарсан коронавирусын халдвар, цар тахал Монгол

Улсад эрчимтэй тархснаас эрүүл мэндийн байгууллагуудын ачаалал эрс нэмэгдсэн, хүний нөөцийн хомсдолд орсон,хил гааль хааж хорио цээрийн хатуу чанга дэглэм, эм эмнэлгийн хэрэгслийн хомсдол,эрүүл мэндийн даатгалын санд төлөвлөгөөгүй ачаалал үүсэж, тусламж үйлчилгээний тохиолдлын тоо эрс нэмэгдсэн ,шинэ тогтоол шийдвэр хяналт шалгалтын шинэчлэл,цахим хөгжүүлэлтийн шинэчлэл зэрэг олон ажлууд зэрэг эхлэсэн ачаалалтай цаг үе байсан хэдийч бид эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний тасалдалгүй байдлыг хангаж, дэмжих бодлогоор санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлж ажиллаж байсныг дурьдах нь зүйтэй.

Холбогдох саналыг тайланд тусгасан тэмдэглэл:

Аймгийн ЭМДХ-ээс ирүүлсэн саналыг тайланд тусгасан тэмдэглэл

2023.05.19

Дархан-Уул аймаг

Д/Д	Холбогдох байгууллагын санал	Тайлбар
1	1.2.2-г утга найруулгыг “Үндэсний зөвлөл нь хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.7-д “эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” гэж заасны дагуу асуудлыг шийдвэрлэсэн тухайгаа able-р хяналтын картаар бүртгэдэг боловч албан бичгээр хариу хүргүүлж ажиллаагүй байна. Тодруулбал ЭМДЕГ-т аймгийн Нэгдсэн эмнэлгээс явуулсан 2021 оны 1/200, 2022 оны 1/417, 1/540, 1/753 тоот албан бичгүүдийн талаар арга хэмжээ авч шийдвэрлэсэн ч хариуг албан бичгээр цаасаар өгч ажиллаагүй байна” гэж өөрчлөх.	Үндэсний зөвлөл нь хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.7-д “эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” гэж заасны дагуу асуудлыг шийдвэрлэсэн тухай албан бичгээр хариу хүргүүлж ажиллаагүй байна. Тодруулбал ЭМДЕГ-т аймгийн Нэгдсэн эмнэлгээс 2021 оны 1/200, 2022 оны 1/417, 1/540, 1/753 тоот албан бичгүүдийн талаар арга хэмжээ авч шийдвэрлэсэн хариуг ирүүлээгүй байна гэж өөрчлөлт оруулав.
2	1.5.3-г утга найруулгыг “Аудитаар гэрээний гүйцэтгэлийг бодитой дүгнэсэн эсэхийг шалгахад “Хангай”, “Анагаах тун”, “Од”, “Мишээл”, “Тэс”, “Фламинго”, “Хос мишээл”, “Армон-Ундраа”, “Шижир”, “Сод фарм” эмийн сангууд MNS5260:2015 стандартын А хавсралтад заасан хүн хүчний хангамжийн шаардлагыг хангаагүй байхад хангалттай гэж үнэлсэн байна” гэж өөрчлөх	Ирүүлсэн санал тайлбар нь 1.5.3-т хамааралгүй байх тул тайланд хэвээр үлдээв.
3	1.6.7-г утга найруулгыг “Аудитаар даатгалын гэрээтэй 32 эрүүл мэндийн байгууллагын 4,903 өвчний түүх, 541 өдрийн эмчилгээ, 974 сэргээн засах эмчилгээ зэрэг нийт 6,418 үйлчлүүлэгчийн тохиолдлыг түүвэрт хамруулан шалгахад эмнэлгүүд цахимын болон нарийвчилсан хяналтаар ирүүлсэн зөрчлийг арилгах чанарыг сайжруулах арга хэмжээ авдаггүй, эмч нартай хариуцлага тооцохгүй байдал давтагдаж байгаагаас ЭМДС-аас 8 эмнэлгийн 114 зөрчилтэй тохиолдолд 57.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ.”	Ирүүлсэн санал тайлбар нь баримтаар нотлогдохгүй байгаа тул тайланд хэвээр үлдээв.
4	3.3.3-г утга найруулгыг “ЭМДЕГ-ын ДАХШҮГ-аас ковидын үеийн тусламж үйлчилгээ болон шинээр хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хийж түүвэрлэгдсэн тохиолдолд хяналт хийгээгүй зөрчлийн талаар тайлбар авч сонсох ажиллагааг явуулж ажилласан байна”	Тайлангийн 3.3.3-ийн утга найруулгыг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн тул тайланд хэвээр үлдээв

5	Дүгнэлт: - ЭМДХ-ээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа гэрээтэй байгууллагуудад сургалт, зөвлөгөө, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн талаар хүргүүлж байгаа боловч нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгахгүй байгаа нь эрүүл мэндийн байгууллагууд шинэчлэлийг хангалтгүй хэрэгжүүлж байна. Зөвлөмж: - Түүвэрт хамрагдсан бүх тохиолдлуудад хяналт хийсэн талаар давхар хяналт хийж хэвших	Дүгнэлт: - Аудитаар нийт үйлчлүүлэгчийн 6418 өвчний түүх, өдрийн эмчилгээ, сэргээн засахын баримтыг түүвэрт хамруулан шалгахад 114 тохиолдолд зөрчил илэрсэн. Энэ нь нийт түүвэрт хамрагдсан тохиолдлын 1.8 хувь байхад эрүүл мэндийн байгууллагууд шинэчлэлийг хангалтгүй хэрэгжүүлсэн гэж дүгнэж болохгүй тул хэвээр үлдээв. Зөвлөмж: - Зөвлөмжийг хэвээр үлдээв.
---	--	---

Боловсруулсан: Ахлах аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Хянасан: Аудитын менежер

С.Санжаажав

Б.Алтанзул

Ч.Гантулга

Г.Батмягмар

З.Мөнгөнцэцэг

Н.Отгонцэцэг

Э.Одгэрэл

У.Батсүрэн

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт тусгагдсан ЭМД-ийн талаар баримтлах бодлогын хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, эмнэл зүйн олон улсын удирдамжийг нэвтрүүлсэн байна.
- Аймгийн Нэгдсэн эмнэлгээс нэхэмжлэлийн хяналт, санхүүжилттэй холбоотой хүсэлт, алба бичгийг ЭМДЕГ-т хүргүүлсэн ч хуульд заасан чиг үүргийн хүрээнд шийдвэрлэж хариу ирүүлээгүй байна.
- ЭМДС-ийн орлогын төлөвлөгөөг тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулж батлуулаагүйгээс орлогын төлөвлөгөөний хэрэгжилт 64.5 хувьтай байна
- ЭМДЕГ болон ЭМДХ-ээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа гэрээтэй байгууллагуудад сургалт, зөвлөгөөг тухай бүр хийж байгаач нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн зөрчлийн тоо өссөн байна
- Эмийн сангийн гэрээний гүйцэтгэлийг бодитой дүгнээгүй байна
- ЭМДС-ийн санхүүжилтийн тогтолцооны өөрчлөлт нь иргэд эрүүл мэндийн байгууллагаа сонгон үйлчлүүлэх, чанартай, хүртээмжтэй үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн ч нэг эмч, сувилагчид ногдох үйлчлүүлэгчийн тоо стандартаас хэтэрсэн байна
- Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглаж байгаа цахим программын хөгжүүлэлт хангалтгүй байгаагаас санхүүжилтээ хугацаанд нь бүрэн авч чаддаггүй байна
- ЭМДХ-ээс нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ түүвэрлэлтийг бүрэн хянаж үзээгүй, зөвхөн бодит цагийн горимоор хянасан зэргээс эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтээ хасуулах, зөрчилтэй тохиолдлыг илрүүлэхгүй байх зэрэг эрсдэлийг бий болгосон байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн ЭМГ-ын дарга Б.Батцэнгэлд зөвлөж байна:

1. ЭМДЕГ-тай гэрээтэй эмийн сангуудад “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” MNS 5260:2015 стандартыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдийг тодорхойлж, судалгаа гаргах

Аймгийн ЭМДХ-ийн дарга А.Энхчимэгт зөвлөж байна:

1. ЭМДЕГ-тай гэрээтэй эмийн сангуудын даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг бодитой дүгнэж, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй эмийн санд холбогдох арга хэмжээг авч ажиллах

2. Түүвэрт хамрагдсан нэхэмжлэлийг чанартай гүйцэтгэж байх

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Б.Мөнхбатад зөвлөж байна:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг даатгуулагч өөрөө хариуцан төлөх төлбөрийг тухайн оношийн хамааралтай бүлгийн иргэнээс төлөх дүнгээр нэхэмжилж төлүүлэх, мөн ЭМД-ийн сангаас иргэний төлөх төлбөрийг илүү нэхэмжлэхгүй байхад анхаарч ажиллах

Аудитаар тогтоосон төлбөрийн актыг төлүүлэх, зөрчлийг давтан гаргаагүй байх талаар арга хэмжээ авч, зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023.05.19



Хавсралт 1.

Түүвэрт хамрагдсан эмийн сангийн тулгалт

№	Компанийн нэр	Эмийн сангийн нэр	Илэрсэн зөрчил	Зөрчигдсөн заалт	Аймгийн ЭМД-ын хэлтсийн үнэлгээ					
					Хүний нөөц		НДШ		Хөнгөлөлттэй эмийн жагсаалт бүхий самбар байршуулсан	
					Авбал зохих оноо	Авсан оноо	Авбал зохих оноо	Авсан оноо	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Аавын Бор хайрхан ХХК	Хангай эмийн сан	АШУҮИС-эм зүйч-D202110883, эм зүйчээр 3 жил ажиллаагүй, 2023.02 сараас эрхлэгч болсон, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, НДШ-ийг бодит цалин хөлснөөс тооцдоггүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 5.2-5.4, 6.3, 11.10,	20	20	10	10	10	10
2	БЭОД ХХК	Анагаах тун эмийн сан	АШУҮИС-Дархан -D202110880, эм зүйчээр 3 жил ажиллаагүй, 2022.02 сараас эрхлэгч болсон, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, ЭМБ-ын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 5.2-5.4, 11.10, 11.4, 14.3.4	20	20	10	10	10	10
3	Гурван тод од ХХК	Од эмийн сан	Одоогоор жор баригч, үйлчлэгч байхгүй, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, ЭМБ-ын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй, программ шинэчлээгүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 6.1, 11.10, 11.4, 14.3.4	20	20	10	10	10	10
4	Мөнхлүн толгой ХХК	Мишээл эмийн сан	ОХУ-Ярослав АИС-эм зүйчээр 2021 онд төгссөн, эм зүйчээр 3 жил ажиллаагүй, 2023.04 сараас эрхлэгч болсон, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, НДШ-ийг бодит цалин хөлснөөс тооцдоггүй, ЭМБ-ын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 5.2-5.4, 6.3, 11.10, 11.4, 14.3.4	20	20	10	5	10	10

5	Очир туяа ХХК	Очиртуяа эмийн сан	Зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, ЭМБ-ын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй, эмийн хөнгөлөлт үзүүлэх жагсаалтыг ил тод байршуулаагүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 11.10, 13.5, 11.4, 14.3.4	20	20	10	10	10	10
6	Унаган Тэс ХХК	Тэс эмийн сан	Үйлчлэгч байхгүй, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, ЭМБ-ын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 6.1, 11.10, 11.4, 14.3.4	20	20	10	10	10	10
7	Фламинго фарм ХХК	Фламинго эмийн сан	Үйлчлэгч байхгүй, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, ЭМБ-ын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 6.1, 11.10, 11.4, 14.3.4	20	20	10	10	10	10
8	Хос мишээл ХХК	Хос мишээл эмийн сан	Үйлчлэгч байхгүй, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, ЭМБ-ын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 11.10, 11.4, 14.3.4	20	20	10	10	10	10
9	Чинтэгш ХХК	Армон ундраа эмийн сан	Эм зүйч давхар ажил эрхэлдэг, үйлчлэгч байхгүй, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, эмийн сангийн программ шинэчлэгдээгүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 6.1, 6.3, 11.10	20	20	10	10	10	10
10	Шижирням ХХК	Шижир эмийн сан	1-р зэрэгт тавигдах хүний нөөцгүй, НДШ-ийг бодит цалин хөлснөөс тооцдоггүй, шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй, ЭМБ-ын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 6.1, 6.3, 11.10, 11.4, 14.3.4	20	20	10	5	10	10
11	Шинэ луут оргил ХХК	Сод фарм эмийн сан	Үйлчлэгч байхгүй, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90% хүрэхгүй	"Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандартын 6.1, 11.10	20	20	10	10	10	10

